

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр
дуусгавар болсон тайлант жилийн

Санхүүгийн тайлан

(Хараат Бус Аудиторын Тайлангийн Хамт)

Агуулга

Хуудас

Компанийн Мэдээлэл	1
Удирдлагын Батламж Мэдэгдэл	2
Хараат Бус Аудиторын Тайлан	3
Санхүүгийн Байдлын Тайлан	6
Ашиг, Алдагдал болон Бусад Дэлгэрэнгүй Орлогын Тайлан	7
Өмчийн Өөрчлөлтийн Тайлан	8
Мөнгөн Гүйлгээний Тайлан	9
Санхүүгийн Тайлангийн Тодруулга	11

Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК

Компанийн мэдээлэл

Албан ёсны хаяг	Монгол Улс, Улаанбаатар Хот, Сүхбаатарын талбай-3
Хувьцаа эзэмшигч	Монгол Улсын Сангийн Яам (100%)
Гүйцэтгэх удирдлага	Х. Алтай, Гүйцэтгэх Захирал Н. Дөл-Эрдэнэ, Захиргаа, Санхүүгийн Газрын Захирал П. Болормаа, Ерөнхий Нягтлан Бодогч
Хараат бус аудитор	Кэй Пи Эм Жи Аудит ХХК Монгол Улс, Улаанбаатар хот 14240, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө, Блю Скай Тауэр, 602 тоот

Удирдлагын Батламж Мэдэгдэл

Компанийн удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК (цаашид “Компани” гэх)-ийн санхүүгийн тайлан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэгдсэн. Удирдлага нь энэхүү санхүүгийн тайлан нь компанийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг үнэн зөв илэрхийлсэн болохыг баталгаажуулах үүрэгтэй.

Компанийн удирдлага нь компанийн санхүүгийн байдлыг үндэслэлтэй, үнэн зөв илэрхийлж чадах, санхүүгийн тайлангууд нь тодруулга 2 ба 3-т дурьдсан шаардлагуудад нийцсэн гэдгийг баталгаажуулах боломжийг хангах зөв зохистой нягтлан бодох бүртгэлийг хөтөлж байгаа гэдгийг баталгаажуулах үүрэгтэй.

Мөн компанийн удирдлага нь компанийн эд хөрөнгийг хадгалан хамгаалах, аливаа заль мэх, зүй бус үйлдлээс сэргийлэх, ийм үйлдлийг илрүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх ерөнхий үүрэгтэй.

Компанийн удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ тохиромжтой нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгон, тууштайгаар даган мөрдөж, үндэслэлтэй, нягт нямбай тооцоолол, үнэлгээ хийж, холбогдох бүх нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдсөн гэж үзэж байна.

Компанийн удирдлагаас Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн тайланг зөвшөөрч батлав.



Н. Дөл-Эрдэнэ
Захиргаа, Санхүүгийн
Газрын Захирал

П. Болормаа
Ерөнхий Нягтлан
Бодогч

Монгол Улс,
Улаанбаатар хот

2019 оны 3 дугаар сарын 20-ны өдөр



Кэй Пи Эм Жи Аудит ХХК
Монгол улс, Улаанбаатар-14240,
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
Энхтайваны өргөн чөлөө 17
Блю Скай Тауэр, 602 тоот

Утас : +976 7011 8101
Факс: +976 7011 8102
www.kpmg.com/mn

Хараат Бус Аудиторын Тайлан

Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн хувьцаа эзэмшигчид:

Дүгнэлт

Бид Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК (цаашид “Компани” гэх)-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, мөн нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудын хураангуй болон тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, компанийн санхүүгийн тайлан нь 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (“СТОУС”)-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (“АОУС”)-ын дагуу гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн Аудитад Аудиторын Хүлээх Үүрэг Хариуцлага хэсэгт харуулсан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөл (“НБЁЗОУСЗ”)-ийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм болон санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой Монгол Улс дахь ёс зүйн зохих шаардлагуудын дагуу компаниас хараат бус байж, НБЁЗОУСЗ-ийн Ёс Зүйн Дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай, зохих үндэслэл болно гэдэгт бид итгэж байна.



Удирдлага болон засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах нь компанийн удирдлагын үүрэг хариуцлага юм. Залилан эсвэл алдааны улмаас материаллагаар буруу илэрхийлэгдээгүй санхүүгийн тайланг бэлтгэж, үнэн зөв толилуулахтай холбоотой удирдлагын шаардлагатай гэж тодорхойлсон дотоод хяналтууд нь мөн энэхүү хариуцлагад хамаарна.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлагын зүгээс компанийн тасралтгүй үйл ажиллагаа эрхлэх чадамжийг үнэлэн, шаардлагатай гэж үзвэл тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг санхүүгийн тайланд тодруулж, компанийг татан буулгах юм уу үйл ажиллагааг нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй үйл ажиллагааны зарчимд суурилан санхүүгийн тайлангаа бэлтгэх үүргийг компанийн удирдлага хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хүлээнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлан нь залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй нотолгоог олж авах, бидний дүгнэлтийг агуулж буй аудиторын тайланг танилцуулах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт хэдий ч АОУС-ын дагуу гүйцэтгэсэн аудит нь бүхий л материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдааны улмаас үүсч болох ба дангаараа эсвэл нэгдсэн дүнгээрээ уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах мэдээлэл хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөхөөр хүлээгдэж байвал материаллаг гэж үзнэ.

АОУС-ын дагуу аудит хийх үед мэргэжлийн үнэлэмж болон мэргэжлийн үл итгэх үзлээр хандахыг аудитын ажлын явцад шаарддаг. Бид мөн:

- Санхүүгийн тайланд залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авдаг. Залилан нь хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах зэрэг явдлуудыг агуулсан байдаг тул залилангаас үүсэх материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдааны улмаас үүсэх буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдлээс харьцангуй их байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горимыг боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.

- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын зохистой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын үндэслэл болон холбогдох тодруулгуудыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн бид олж авсан нотолгоондоо тулгуурлан компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа эрхлэх чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Материаллаг тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл бид аудиторын тайланд санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл энэхүү тодруулга нь хангалтгүй бол дүгнэлтээ хязгаарлах шаардлагатай болдог. Бид дүгнэлтээ аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд үндэслэн гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал нь компанийг тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- Санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц болон агуулгыг тодруулгуудын хамт үнэлж, санхүүгийн тайлан нь холбогдох ажил гүйлгээнүүд болон үйл явдлуудыг үнэн зөв илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн цар хүрээ, хугацаа болон аудитын явцад илрүүлсэн томоохон асуудлууд, тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцдаг.


Кэй Пи Эм Жи Аудит ХХК
Монгол Улс, Улаанбаатар хот
2019 оны 3 дугаар сарын 20-ны өдөр

Энэхүү тайлан нь аудитын тайлангийн өдөр буюу 2019 оны 3 дугаар сарын 20-ны өдрөөр хүчин төгөлдөр үйлчилнэ. Аудитын тайлангийн өдөр болон энэхүү тайланг хэрэглэх хугацааны хооронд тохиолдож болох аливаа тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдал нь уг санхүүгийн тайлан болон тодруулгад материаллаг нөлөө үзүүлж болох юм. Тиймээс аудитын тайланг хэрэглэгчид нь уг тайлагналын үеийн дараах үйл явдал, нөхцөл байдлын нөлөөллийг дээрх аудитын тайланд тусгаагүйг анхаарна уу. Энэхүү тайлан нь зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчид зориулагдсан болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө үүрэг, хариуцлага хүлээхгүй болно.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх
Санхүүгийн Байдлын Тайлан

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<i>Тод.</i>	2018	2017
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	5	2,172,002	2,264,092
Биет бус хөрөнгө	6	1,192,669	1,271,900
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		3,364,671	3,535,992
Эргэлтийн хөрөнгө			
Бараа материал	7	26,340	16,331
Бусад хөрөнгө оруулалт	8	1,000	1,000
Урьдчилгаа		16,945	14,480
Дансны авлага	9	299,461	82,852
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	10	830,386	1,306,884
Бусад эргэлтийн хөрөнгө		13,160	13,160
Эргэлтийн хөрөнгийн дүн		1,187,292	1,434,707
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		4,551,963	4,970,699
ӨР ТӨЛБӨР БОЛОН ЭЗДИЙН ӨМЧ			
Эздийн өмч			
Хувьцаат капитал	11	23,130,594	21,884,000
Бусад нөөц	11	458,684	1,705,278
Хуримтлагдсан алдагдал		(20,251,939)	(18,992,094)
Эздийн өмчийн дүн		3,337,339	4,597,184
Богино хугацаат өр төлбөр			
Дансны өглөг	12	1,052,005	325,000
Орлогын албан татварын өглөг	18	5,451	5,136
Бусад өглөг	12	156,032	41,324
Урьдчилж орсон орлого		1,136	2,055
Богино хугацаат өр төлбөрийн дүн		1,214,624	373,515
ӨР ТӨЛБӨР БОЛОН ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		4,551,963	4,970,699

Энэхүү санхүүгийн тайлангийн хавсаргасан тодруулгыг үзнэ үү.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
 Ашиг, Алдагдал болон Бусад Дэлгэрэнгүй Орлогын Тайлан

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<i>Тод.</i>	2018	2017
Борлуулалтын орлого	13	1,656,960	1,830,553
Нийт орлого		1,656,960	1,830,553
Ерөнхий ба удирдлагын зардал	14	(1,290,434)	(1,210,451)
Миллениум Ай Ти системтэй холбоотой тайлант жилийн зардал	15	(1,273,769)	(908,749)
Авлагын үнэ цэнийн бууралтын зардал	20	(18,171)	(27,375)
Санхүүгийн орлого	16	94,606	55,054
Гадаад валютын ханшийн цэвэр олз / (гарз)	17	(30,306)	15,771
Бусад орлого		37,888	16,956
Тайлант үеийн үйл ажиллагааны алдагдал		(823,226)	(228,241)
Миллениум Ай Ти системтэй холбоотой өмнөх жилийн зардал*	15	(427,175)	-
Татварын өмнөх алдагдал		(1,250,401)	(228,241)
Орлогын албан татварын зардал	18	(9,444)	(4,920)
Тайлант үеийн алдагдал		(1,259,845)	(233,161)
Тайлант үеийн нийт дэлгэрэнгүй алдагдал		(1,259,845)	(233,161)

(*) Тайлант жилийн орлогын татварын өмнөх үйл ажиллагааны алдагдал 823,226 мянган төгрөг байна. 2018 оны 10 дугаар сард OPS үйлчилгээний гэрээг сунгасантай холбоотойгоор 2017 онд хамаарах Миллениум Ай Ти системийн зардал болох 427,175 мянган төгрөгийг 2018 оны зардалд хүлээн зөвшөөрсөн. Дэлгэрэнгүйг Тодруулга 15-аас үзнэ үү.

Энэхүү санхүүгийн тайлангийн хавсаргасан тодруулгыг үзнэ үү.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
 Өмчийн Өөрчлөлтийн Тайлан

(Мянган төгрөгөөр)	Хувьцаат капитал	Бусад нөөц	Хуриглагдсан алдагдал	Нийт эздийн өмч
2016 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй алдагдал	21,884,000	458,684	(18,758,933)	3,583,751
Өмчид шууд бүртгэсэн эзэмшигчидтэй хийсэн ажил гүйлгээ	-	-	(233,161)	(233,161)
Хувьцаа эзэмшигчээс оруулсан санхүүжилт	-	1,246,594	-	1,264,594
2017 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй алдагдал	21,884,000	1,705,278	(18,992,094)	4,597,184
Хувьцаат капитал руу хөрвүүлэлт	1,246,594	(1,246,594)	(1,259,845)	(1,259,845)
2018 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	23,130,594	458,684	(20,251,939)	3,337,339

Энэхүү санхүүгийн тайлангийн хавсаргасан тодруулгыг үзнэ үү.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
 Мөнгөн Гүйлгээний Тайлан

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<i>Тод.</i>	2018	2017
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Тайлант үеийн алдагдал		(1,259,845)	(233,161)
Тохируулга:			
Элэгдэл ба хорогдол	14,15	631,260	620,930
Авлагын үнэ цэнийн бууралтын нөөц	14	18,171	27,375
Орлогын албан татварын зардал	18	9,444	4,920
Ханшийн зөрүүний хэрэгжээгүй цэвэр (олз) гарз	17	34,149	(30,287)
Хүүгийн орлого	16	(94,606)	(55,054)
Ажлын капиталын өөрчлөлтөөс өмнөх үйл ажиллагааны ашиг (алдагдал)		(661,427)	334,723
Хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлт:			
Дансны авлага		(234,780)	38,266
Урьдчилгаа		(2,465)	(12,110)
Бараа материал		(10,009)	(3,331)
Дансны болон бусад өглөг		807,205	(847,376)
Урьдчилж орсон орлого		(919)	2,055
		(102,395)	(487,773)
Хүлээн авсан хүүгийн орлого		94,606	55,054
Төлсөн орлогын албан татвар		(9,129)	(918)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		(16,918)	(433,637)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Худалдан авсан үндсэн хөрөнгө	5	(37,266)	(21,889)
Худалдан авсан биет бус хөрөнгө	6	(422,673)	-
Засгийн Газрын үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалт		-	(194,396)
Засгийн Газрын үнэт цаасны буцаан төлөлт		-	194,396
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		(459,939)	(21,889)

Энэхүү санхүүгийн тайлангийн хавсаргасан тодруулгыг үзнэ үү.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
 Мөнгөн Гүйлгээний Тайлан, үргэлжлэл

	<u>Тод.</u>	<u>2018</u>	<u>2017</u>
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Хувьцаа эзэмшигчээс оруулсан санхүүжилт		-	1,246,594
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		-	1,246,594
Ханшийн өөрчлөлтийн нөлөөлөл		359	674
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт (бууралт)		(476,498)	791,742
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10	1,306,884	515,142
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	10	830,386	1,306,884

Энэхүү санхүүгийн тайлангийн хавсаргасан тодруулгыг үзнэ үү.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

1. Ерөнхий мэдээлэл

Монголын Хөрөнгийн Бирж Төрийн Өмчит ХК (цаашид “Компани” гэх) нь 1991 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр улсын томоохон аж ахуйн нэгжүүдийг хувьчлах Засгийн Газрын өмч хувьчлалын бодлогыг хэрэгжүүлэх хэрэгсэл хэлбэрээр үүсгэн байгуулагдсан. Компанийн албан ёсны хаяг нь Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатарын талбай-3 юм.

Компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь хөрөнгө оруулалтын арилжааг дэмжих зах зээлийг бий болгох явдал юм. Компанийг Монгол Улсын Сангийн Ямаар дамжин Монгол Улсын Засгийн Газар 100% эзэмшдэг.

2. Санхүүгийн тайлагналын зарчим

(1) Тайланг бэлтгэхэд баримталсан стандарт

Энэхүү санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид “СТОУС” гэх)-ын дагуу бэлтгэсэн. Компанийн мөрдсөн нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудыг дор хураангуйлан харуулсан болно. Тайлант жилийн толилуулгатай нийцүүлэх үүднээс зарим харьцуулсан үзүүлэлтүүдийг дахин ангилсан.

(2) Үнэлгээний суурь

Энэхүү санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад өөрөөр тодруулсанаас бусад тохиолдолд санхүүгийн тайланг түүхэн өртгийн зарчимд үндэслэн бэлтгэсэн.

(3) Үйл ажиллагааны болон толилуулгын валют

Энэхүү санхүүгийн тайланг компанийн бүртгэлийн валют болох Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр толилуулсан бөгөөд энэ нь компанийн үйл ажиллагаа явуулж буй гол эдийн засгийн орчны үндсэн валют болно. Санхүүгийн тайланг төгрөгөөр мянгачилж толилуулсан.

(4) Тасралтгүй үйл ажиллагааны зарчим

Санхүүгийн тайлан нь тасралтгүй үйл ажиллагааны зарчимд үндэслэн бэлтгэгдсэн бөгөөд энэ нь компани ойрын ирээдүйд хөрөнгөө бизнестээ хэвээр үлдээж, өр төлбөрөө төлж, үйл ажиллагаагаа тасралтгүй хэвийн явуулна гэдгийг илэрхийлнэ.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

2. Санхүүгийн тайлагналын зарчим, үргэлжлэл

(4) Тасралтгүй үйл ажиллагааны зарчим, үргэлжлэл

Компани нь 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилд 1,259,845 мянган төгрөгийн цэвэр алдагдалтай, тухайн өдрөөрх компанийн богино хугацаат өр төлбөр нь эргэлтийн хөрөнгийн дүнгээс 27,332 мянган төгрөгөөр илүү илэрхийлэгдсэн байна. Энэхүү алдагдал болон богино хугацаат өр төлбөр нь хөрөнгийн зах зээлийн дэд бүтэц болох Миллениум Ай Ти системийн ашиглалтын зардлыг “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК дангаар хариуцаж байсантай холбоотой юм. Тайлант жилд компанийн хувьцаа эзэмшигч Сангийн Яамны зүгээс уг системийн ашиглалтын зардлыг системийг ашиглагч дэд бүтцийн байгууллагуудтай хувааж төлөх талаар чиглэл өгсөн бөгөөд тус чиглэлийн хүрээнд цаашид компани Миллениум Ай Ти системийн ашиглалтын зардлын 58.6%-ийг хариуцах саналыг компанийн 2019 оны Бизнес төлөвлөгөөнд тусгаж, төсөв төлөвлөгөөг Төлөөлөн Удирдах Зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулсан. Үүний үр дүнд, компани 2019 оноос эхлэн Миллениум Ай Ти системтэй холбоотой зардал 40 хувиар буурахаар хүлээгдэж байгаа бөгөөд Сангийн Яамны зөвлөмжийг мөрдөж байгаа болно.

Компани нь 2019-2021 оны үйл ажиллагааны стратеги, зорилго чиглэлийг дараах зорилтуудад чиглүүлж ажиллахаар төлөвлөсөн бөгөөд ингэснээр компанийн 2019 онд алдагдал 2018 онтой харьцуулахад 40%-иар буурч, үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр ашгийг нэмэгдүүлэхээр төлөвлөж байна. Үүнд:

1. Үнэт цаасны зах зээл дээрх бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх;
2. Бүртгэлтэй хувьцаат компаниудын үнэ цэнийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
3. Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
4. Хөрөнгийн зах зээлд оролцогчдын үйл ажиллагааг бодлогоор дэмжих;
5. Дотоод үйл ажиллагааг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэх.

Компанийн хувьцаа эзэмшигч Монгол Улсын Засгийн Газраас Сангийн Яамаар дамжуулан дэмжлэг үзүүлсээр байгаа. Аудитлагдсан санхүүгийн тайлан гарсан өдрөөс хойш дор хаяж 12 сарын хугацаанд компани ирээдүйд гарах гэрээний төлбөрүүд болон бизнесийн явцад үүсч байдаг өр төлбөрүүдийг төлөх хангалттай хэмжээний эргэлтийн болон капиталын хөрөнгөтэй гэж үзэж байгаа.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

2. Санхүүгийн тайлагналын зарчим, үргэлжлэл

(5) Таамаглал, тооцоолол болон үнэлэмжийн хэрэглээ

Санхүүгийн тайланг СТОУС-д нийцүүлэн бэлтгэх үйл явц нь таамаглал, тооцоолол болон үнэлгээ хэрэглэхийг удирдлагаас шаарддаг ба энэхүү таамаглал, тооцоолол, үнэлэмж нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэгжилт, мөн хөрөнгө, өр төлбөр, орлого зардлын зүйлсийн дүнг тодорхойлоход нөлөөлдөг. Гүйцэтгэлээрх үр дүн нь эдгээр тооцооллоос зөрүүтэй байж болно.

Удирдлага эдгээр тооцоолол болон түүнд хэрэглэсэн таамаглалыг байнга хянаж байдаг. Нягтлан бодох бүртгэлийн тооцоололд аливаа өөрчлөлт гарсан тохиолдолд тухайн өөрчлөлт гарсан тайлант жил болон ирээдүйн тайлант жилүүдэд уг тооцооллын өөрчлөлтийг хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн тайланд мэдэгдэхүйц нөлөө бүхий нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд хэрэглэгдсэн таамаглал, тооцоолол, үнэлэмжийн талаарх мэдээлэл болон дараагийн тайлант үед хамаарах материаллаг залруулгын нөлөө бүхий эрсдлийн үндэслэл болон тооцооллын талаарх мэдээллийг доорх тодруулгад тусгасан:

- Тодруулга 3(4)(iii) – Үндсэн хөрөнгийн ашиглагдах хугацаа;
- Тодруулга 3(5) – Биет бүс хөрөнгийн ашиглагдах хугацаа;
- Тодруулга 3(6)(i) болон 8 – Дансны авлагын нөөц.

(6) Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудад орсон өөрчлөлтүүд

2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэд хэдэн шинэ стандартууд мөрдөгдөж эхэлсэн. Удирдлага нь эдгээр стандартуудыг санхүүгийн тайлангуудад материаллаг нөлөө үзүүлэхгүй хэмээн үнэлсэн. Компанид хамгийн их хамааралтай стандартуудыг доор дурьдсан болно.

А. СТОУС 15 Харилцагчтай байгуулсан гэрээний орлого

Компани нь 2018 онд СТОУС 15-ыг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэ нь 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр болон түүнээс хойшх тайлант үеүдэд ашиглагдах, харилцагчтай байгуулсан гэрээнээс хүлээн зөвшөөрсөн орлогын санхүүгийн тайлагналын стандарт юм. СТОУС 15 нь хүлээн зөвшөөрөх орлогын хэмжээ болон хугацааг тодорхойлсон иж бүрэн тогтолцоог бий болгосон. Энэхүү стандартын гол зарчим нь байгууллага харилцагчид үзүүлэхээр тохиролцсон үйлчилгээгээ үзүүлсний хариуд хүлээн авах төлбөрийн дүнгээр орлогоо хүлээн зөвшөөрөх явдал юм. Уг шинэ стандарт нь дараах 5 алхамт арга хандлагыг танилцуусан:

- Алхам 1: Харилцагчтай байгуулсан гэрээг тодорхойлох.
- Алхам 2: Гэрээнд тусгагдсан тусдаа гүйцэтгэлийн үүргүүдийг тодорхойлох.
- Алхам 3: Ажил гүйлгээний үнийг тодорхойлох.
- Алхам 4: Ажил гүйлгээний үнийг тусдаа гүйцэтгэлийн үүргүүдэд хуваарилах.
- Алхам 5: Гүйцэтгэлийн үүрэг бүрэн хангагдсан үед орлогыг хүлээн зөвшөөрөх.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

2. Санхүүгийн тайлагналын зарчим, үргэлжлэл

(6) Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудад орсон , үргэлжлэл

А. СТОУС 15 Харилцагчтай байгуулсан гэрээний орлого, үргэлжлэл

Удирдлага нь СТОУС 15-ын шаардлагууд болон өөрсдийн төрөл бүрийн үйл ажиллагааны гэрээнүүдийн шинжилгээнд тулгуурлан дотоод орлого хүлээн зөвшөөрөх бодлогодоо үнэлгээ хийж гүйцэтгэсэн. Энэхүү шинжилгээн дээр тулгуурлан, удирдлага нь гүйцэтгэлийн үүрэг тус бүрийн хувьд орлого хүлээн зөвшөөрөх хугацаа нь компанийн өмнөх практикт нийцэж буйг харгалзан үзэж, СТОУС 15-ын хэрэглээ нь компанийн 2018 санхүүгийн байдал, үр дүнд мэдэгдэхүйц нөлөө үзүүлээгүй болно.

Б. СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүр

Компани нь 2018 онд СТОУС 9-ийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд СТОУС 9 нь НББОУС 39-ийг орлох болсон ба санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийн гурван гол хэсэг болох (i) Ангилал ба хэмжилт; (ii) Үнэ цэнийн бууралтын аргачлал болон (iii) Хеджийн нягтлан бодох бүртгэлд нөлөөлж 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Компанид учирж болзошгүй нөлөөллийг үнэлсний үр дүнд дараах чухал дүгнэлтүүдийг хийсэн:

Санхүүгийн хөрөнгийн шинэ ангилал нь компанийн тухайн санхүүгийн хөрөнгийг удирдах бизнес загвар болон түүний мөнгөн урсгалын шинж чанарт үндэслэдэг. Эдгээр шинж чанарууд дээр үндэслэн санхүүгийн хөрөнгийг дараах хэмжилтийн төрөлд ангилна: (i) хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө, (ii) бусад дэлгэрэнгүй орлогоорх (ээдийн өмч) бодит үнэ цэнээр илэрхийлсэн санхүүгийн хөрөнгө болон (iii) ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлсэн санхүүгийн хөрөнгө. Хийсэн үнэлгээгээр компанийн одоогийн бизнесийн загвар болон шинж чанарт үндэслэн санхүүгийн хөрөнгийн ангилал болон хэмжилтэнд материаллаг өөрчлөлт үзүүлээгүй болно.

Шинэ стандарт нь өмнөх НББОУС 39-ийн “алдагдал хүлээх үйл явдал тохиолдсон байх” үнэ цэнийн бууралтын загварыг “Хүлээгдэж буй алдагдал” загвараар орлох болсон. Энэхүү шинэ загвар нь санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх өдрөөр тухайн санхүүгийн хөрөнгийн зээлийн эрсдлийн өөрчлөлтөөс, эсвэл үг стандартад зөвшөөрсөн зарим санхүүгийн хөрөнгө дээр “хялбарчилсан” загварыг ашигласнаас үүдэн тайлант жилээс хойш 12 сарын хугацаанд эсвэл санхүүгийн хөрөнгийн ашиглалтын хугацаанд гарч болзошгүй хүлээгдэж буй алдагдлыг хүлээн зөвшөөрөхийг шаарддаг.

Компани нь дансны авлага дээрх хөрөнгийн ашиглалтын хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тооцоолох зорилгоор тухайн авлагууд дээр “хялбарчилсан” аргыг хэрэгжүүлсэн (Тодруулга 3(2)-ыг харна уу). 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөр СТОУС 9-ийн хэрэгжүүлэлт нь компанийн санхүүгийн байдал болон үр дүнд материаллаг нөлөө үзүүлээгүй болно.

СТОУС 9-ийг буцаан мөрдөх зарчмаар хэрэгжүүлсэн бөгөөд тухайн стандартын анхны хэрэгжилтийн нөлөөллийг 2018 оны санхүүгийн байдлын тайлангийн дансны эхний үлдэгдлийн залруулгаар хүлээн зөвшөөрөх юм. Иймд 2017 оны харьцуулагдах дүнд өөрчлөлт орохгүй бөгөөд НББОУС 39-ийн дагуу тайлагнасан хэвээр байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд

Доор хураангуйлсан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудыг энэхүү санхүүгийн тайланд толилуулсан бүх тайлант жилүүдэд тууштай хэрэглэсэн болно.

(1) Гадаад валютаар хийгдсэн гүйлгээ

Гадаад валютаар гарсан ажил гүйлгээг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлж бүртгэдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө, өр төлбөрийн мөнгөн зүйлсийг балансын өдрийн хаалтын ханшаар төгрөг рүү хөрвүүлэн илэрхийлдэг.

Бодит үнэ цэнээр хэмжигдэж, гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус хөрөнгө, өр төлбөрийн зүйлсийг тухайн бодит үнэ цэнийг тодорхойлсон өдрийн албан ханшаар бүртгэлийн валют рүү хөрвүүлдэг. Түүхэн өртгөөр хэмжигдэж, гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар тайлагнадаг.

(2) Санхүүгийн хэрэглүүр

2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхдэн мөрдсөн бодлого

Компани дериватив бус санхүүгийн хөрөнгийг дараах ангиллын дагуу ангилдаг. Үүнд: хорогдуулсан өртгөөр хэмжсэн; бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнэ (БДОБУЦ) болон ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр (ААБУЦ) хэмжсэн санхүүгийн хөрөнгө зэрэг багтана. Компани дериватив бус санхүүгийн өр төлбөрийг хорогдуулсан өртгөөр хэмжсэн болон ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн өр төлбөр гэж ангилдаг.

(i) Дериватив бус санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр – хүлээн зөвшөөрөлт ба үл хүлээн зөвшөөрөлт

Компани дансны авлага болон өрийн үнэт цаасыг анх үүссэн өдөр нь хүлээн зөвшөөрнө. Бусад бүх санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрийг анх гэрээний нөхцөл компанид хамааралтай болох тэр үед хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн хөрөнгийн мөнгөн гүйлгээнд хамаарах гэрээний эрхийн хүчинтэй хугацаа дууссан эсвэл уг санхүүгийн хөрөнгийн мөнгөн гүйлгээг хүлээн авах гэрээний эрхийг шилжүүлсэн бөгөөд санхүүгийн хөрөнгийн эзэмшилтэй холбоотой бүх эрсдэл, өгөөжийг бараг бүгдийг нь шилжүүлсэн эсвэл шилжүүлээгүй бөгөөд эрсдэл, өгөөжийг хадгалаагүй бөгөөд хяналтыг авч үлдээгүй бол уг санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрдөг.

Компани нь санхүүгийн өр төлбөрийг гэрээнд тодорхойлсон үүрэг хариуцлага дуусгавар болсон, цуцлагдсан эсвэл хугацаа дуусгавар болсон үед санхүүгийн байдлын тайланд үл хүлээн зөвшөөрдөг. Компани нь санхүүгийн өр төлбөрийн нөхцөл өөрчлөгдөж, өөрчлөгдсөн өр төлбөрийн мөнгөн урсгал материаллаг хэмжээнд ялгаатай бөгөөд өөрчлөгдсөн нөхцөлд үндэслэн шинэ санхүүгийн өр төлбөрийг бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрсөн тохиолдолд өмнөх санхүүгийн өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрдөг.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд, үргэлжлэл

(2) Санхүүгийн хэрэглүүр, үргэлжлэл

(ii) Дериватив бус санхүүгийн хөрөнгө – хэмжилт

(а) Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө

Санхүүгийн хөрөнгө нь ААБҮЦ-ээр илэрхийлэгдээгүй бөгөөд дараах хоёр шалгуурыг хангасан буюу (i) гэрээгээр орж ирэх мөнгөн урсгалыг цуглуулах зорилгоор эзэмших бизнесийн загвартай (ii) гэрээний нөхцөл нь хөрөнгийн гэрээгээрх үндсэн болон хүүгийн төлбөрийн мөнгөн урсгал тогтсон өдрөө хөрөнгийн үлдэгдэлд тооцогддог бол уг хөрөнгийг хорогдуулсан өртгөөр хэмжинэ.

Эдгээр санхүүгийн хөрөнгийг анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа тайлант үеүдэд үр ашигт хүүгийн арга ашиглан хорогдуулсан өртгөөр хэмжинэ. Хорогдуулсан өртөг нь үнэ цэнийн бууралтын алдагдлаар буурдаг. Хүүгийн орлого, гадаад валютын ханшийн зөрүүгийн олз, гарз болон үнэ цэнийн бууралтын алдагдлыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

(б) Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө

Санхүүгийн хөрөнгө нь ААБҮЦ-ээр илэрхийлэгдээгүй бөгөөд дараах хоёр шалгуурыг хангасан буюу (i) гэрээгээр орж ирэх мөнгөн урсгалыг цуглуулах болон борлуулах зорилгоор эзэмших бизнесийн загвартай (ii) гэрээний нөхцөл нь хөрөнгийн гэрээгээрх үндсэн болон хүүгийн төлбөрийн мөнгөн урсгал тогтсон өдрөө хөрөнгийн үлдэгдэлд тооцогддог бол уг хөрөнгийг бусад дэлгэрэнгүй орлогоор хэмжсэн санхүүгийн хөрөнгө хэмжинэ.

Эдгээр санхүүгийн хөрөнгийг анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа бодит үнэ цэнээр хэмжинэ. Өрийн хэрэглүүрийн үр ашигт хүүгийн арга ашиглан тооцсон хүүгийн орлого, гадаад валютын ханшийн зөрүүгийн олз, гарз болон үнэ цэнийн бууралтын алдагдлыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Бусад цэвэр олз, гарзыг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрнө.

(в) Ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө

Дээр дурдсан хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө, эсвэл БДОБҮЦ-ээр хэмжсэн санхүүгийн хөрөнгөөр гэж ангилагдаагүй бүх санхүүгийн хөрөнгийг ААБҮЦ-ээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө гэж ангилна. Эдгээр санхүүгийн хөрөнгийг анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа бодит үнэ цэнээр хэмжинэ. Хүүгийн орлого, ногдол ашгийн орлого зэрэг багтсан цэвэр олз, гарзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

(iii) Дериватив бус санхүүгийн өр төлбөр

Компани дериватив бус санхүүгийн өр төлбөрийг хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн өр төлбөр, эсвэл ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн өр төлбөр гэж ангилдаг. Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн өр төлбөр гэдэгт арилжаалах зориулалтаар эзэмших нөхцлийг хангасан эсвэл анх хүлээн зөвшөөрөх үед уг өр төлбөрийг ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр нь тодорхойлсон байвал энэ ангиллын санхүүгийн өр төлбөрт хамааруулна. Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн өр төлбөр нь бодит үнэ цэнээрээ хэмжигдэх бөгөөд гарсан аливаа өөрчлөлтийг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд, үргэлжлэл

(2) Санхүүгийн хэрэглүүр, үргэлжлэл

(iii) *Дериватив бус санхүүгийн өр төлбөр, үргэлжлэл*

Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн өр төлбөрөөс бусад дериватив бус санхүүгийн өр төлбөрийг бусад санхүүгийн өр төлбөрийн ангилалд хамааруулдаг. Анхны хүлээн зөвшөөрөлтийн өдөр бусад санхүүгийн өр төлбөрийг хорогдуулсан өртгөөр хэмждэг ба анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа үед бусад санхүүгийн өр төлбөрийг үр ашигт хүүгийн аргаар хорогдуулсан өртгөөр хэмждэг. Хүүгийн зардал, гадаад валютын ханшийн зөрүүгийн олз, гарзыг ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Бусад цэвэр олз, гарзыг мөн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

(iv) *Санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг цэвэр дүнгээр тусгах нь*

Компани хүлээн зөвшөөрөгдсөн дүнг хооронд нь хааж, цэвэр дүнгээр тусгах, хууль, эрх зүйн үндэслэлтэй эсэх, мөн цэвэр дүнгээр нь төлбөр хийх эсвэл нэгэн зэрэг хөрөнгийг борлуулах, өр төлбөрийг барагдуулах зорилготой үед санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хааж санхүүгийн байдлын тайланд цэвэр дүнгээр нь тусгадаг.

2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнөх мөрдсөн бодлого

(i) *Үүсмэл бус санхүүгийн хөрөнгө*

Компани нь зээл болон авлагыг анх үүссэн тухай бүр нь хүлээн зөвшөөрч, бүртгэсэн. Бусад бүх санхүүгийн хөрөнгүүдийг (ашиг, алдагдлын дараах бодит үнэ цэнээр тодорхойлогдсон хөрөнгүүдийг оролцуулаад) хэлцэл хийгдсэн өдөр буюу тухайн санхүүгийн хэрэгслийн хувьд компани гэрээний нэг тал болсон өдрөөр хүлээн зөвшөөрдөг байсан.

Санхүүгийн хөрөнгийн мөнгөн гүйлгээнд хамаарах гэрээний эрхийн хүчинтэй хугацаа дууссан эсвэл уг санхүүгийн хөрөнгийн мөнгөн гүйлгээг хүлээн авах гэрээний эрхийг шилжүүлсэн бөгөөд санхүүгийн хөрөнгийн эзэмшилтэй холбоотой бүх эрсдэл, өгөөжийг бараг бүгдийг нь шилжүүлсэн бол уг санхүүгийн хөрөнгийг данснаас хасдаг байсан.

Компани санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг цэвэр дүнгээр бүртгэх хууль, эрх зүйн үндэслэлтэй, мөн компани цэвэр сууриар барагдуулах эсвэл хөрөнгийг борлуулах үедээ өр төлбөрийг нэгэн зэрэг барагдуулах төлөвлөгөөтэй тохиолдолд л санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг санхүүгийн байдлын тайланд цэвэр дүнгээр тусгаж, толилуудаг байсан.

Компанийн үүсмэл бус санхүүгийн хөрөнгө нь авлага юм.

(ii) *Авлага*

Авлага нь идэвхитэй зах зээлд арилжаалагдахгүй тогтмол дүнтэй эсвэл, төлөгдөх үнийн дүн нь тодорхойлогдохуйц санхүүгийн хөрөнгө юм. Уг хөрөнгийг бодит үнэ цэнэ дээр тухайн ажил гүйлгээтэй холбоотой гарсан шууд зардлыг нэмсэн дүнгээр анх хүлээн зөвшөөрдөг. Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа авлагыг үр ашигт хүүгийн аргаар тооцон хорогдуулж, хорогдуулгыг хассан дүнгээр илэрхийлдэг байсан.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд, үргэлжлэл

(2) Санхүүгийн хэрэглүүр, үргэлжлэл

(iii) Үүсмэл бус санхүүгийн өр төлбөр

Компани нь гаргасан өрийн бичиг, өр төлбөрийг тухайн ажил гүйлгээ үүссэн өдрөөр хүлээн зөвшөөрч, бүртгэдэг. Бусад бүх санхүүгийн өр төлбөрийг (ашиг, алдагдлын дараах бодит үнэ цэнээр тодорхойлогдсон хөрөнгүүдийг оролцуулаад) хэлцэл хийгдсэн өдөр буюу тухайн санхүүгийн хэрэгслийн хувьд компани гэрээний нэг тал болсон өдрөөр хүлээн зөвшөөрдөг байсан.

Компани гэрээний үүргээс чөлөөлөгдсөн, гэрээг цуцалсан, гэрээний хугацаа дуусгавар болсон тохиолдолд санхүүгийн өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрдөг байсан.

Компани үүсмэл бус санхүүгийн өр төлбөрийг бусад санхүүгийн өр төлбөр хэсэгт ангилдаг. Эдгээр санхүүгийн өр төлбөрийг бодит үнэ цэнээс тухайн ажил гүйлгээтэй холбоотой гарсан шууд зардлыг хассан дүнгээр анх хүлээн зөвшөөрдөг. Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа үед эдгээр санхүүгийн өр төлбөр нь үр ашигт хүүгийн аргаар тооцон хорогдуулсан өртгөөр илэрхийлэгддэг байсан.

Компани дансны болон бусад өглөг гэсэн үүсмэл бус санхүүгийн өр төлбөрүүдтэй байсан.

(3) Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нь касс дахь бэлэн мөнгө болон харилцах дахь мөнгөнөөс бүрдэнэ. Мөнгөн хөрөнгө нь валютын төрлөөс хамааран ангилагдан бүртгэгддэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгийг балансын өдрийн Монгол Банкнаас зарласан хаалтын ханшаар төгрөгт хөрвүүлэн илэрхийлдэг.

(4) Үндсэн хөрөнгө

(i) Хүлээн зөвшөөрөх үеийн хэмжилт

Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаж буй үндсэн хөрөнгийн зүйлсийг анх дансанд өртгөөр нь хэмжиж хүлээн зөвшөөрдөг. Өртөгт тухайн хөрөнгийг худалдан авахтай шууд холбогдон гарсан зардлууд багтдаг. Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараагаар үндсэн хөрөнгийн дансны үнэ нь түүний өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүн байдаг. Үндсэн хөрөнгийн зүйлсийг борлуулснаас үүссэн олз, гарзыг үндсэн хөрөнгийн дансны үнэ болон цэвэр борлуулалтын орлогын зөрүүгээр тодорхойлдог.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд, үргэлжлэл

(4) Үндсэн хөрөнгө, үргэлжлэл

(ii) Дараа үеийн зардлууд

Дараа үеийн зардлыг зөвхөн эдийн засгийн ирээдүйн үр өгөөжийг хүртэх магадлалтай гэдэг нь тогтоогдсон үед капиталжуулан бүртгэдэг. Урсгал засварын зардлыг гарсан тухайн тайлант үед зардлаар хүлээн зөвшөөрдөг.

(iii) Элэгдэл

Үндсэн хөрөнгийн зүйлсийг бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн ашиглалтын жилээр тооцон шулуун шугамын аргаар элэгдүүлж, дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэдэг. Түрээсийн хөрөнгийн хувьд түрээслэгч нь түрээсийн хугацааны эцэст хөрөнгийн өмчлөлийн эрхийг авах нь тодорхой биш бол тухайн хөрөнгийг түрээсийн хугацаанд нь эсвэл түүнийг ашиглахаар тооцсон хугацааны аль богино хугацаагаар нь элэгдүүлдэг.

Үндсэн хөрөнгийн зүйлсийн тайлант жил болон түүнтэй зэрэгцүүлэх хугацаанд тооцсон эдийн засгийн элэгдүүлэх хугацаа дараах байдалтай байна.

• Барилга байгууламж	60 жил
• Тээврийн хэрэгсэл	6 жил
• Тавилга, эд хогшил	5 - 10 жил
• Тоног төхөөрөмж	3 - 10 жил

Хөрөнгийн элэгдэл байгуулах арга, ашиглахаар тооцсон хугацаа болон үлдэх өртгийг тайлант жил бүрийн эцэст дахин хянаж, шаардлагатай тохиолдолд тохируулга хийдэг.

(5) Биет бус хөрөнгө

Биет бус хөрөнгийг анх өртгөөр нь бүртгэх бөгөөд анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа үед өртгөөс нь хуримтлагдсан хорогдол болон хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүнгээр тайлагнадаг.

Биет бус хөрөнгийн хорогдлыг ашиглахад бэлэн болсон өдрөөс эхлэн тооцоолсон ашиглалтын хугацаанд нь шулуун шугамын аргаар хорогдуулдаг ба үлдэх өртөг нь тэг байдаг. Ашиглалтын хугацаа нь тодорхой биет бус хөрөнгийн хувьд хорогдол тооцох хугацаа болон аргыг тайлант үе бүрийн эцэст хянадаг.

Программ хангамжийн лицензийн ашиглалтын хугацаа нь лицензийн хүчинтэй байх хугацааны дагуу тооцоолон тогтоогдсон.

Дараа үеийн зардлыг зөвхөн эдийн засгийн ирээдүйн өгөөж нь тухайн хөрөнгийн хувьд нэмэгдэж байгаа үед капиталжуулдаг. Бусад бүх зардлыг гарсан үед нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд, үргэлжлэл

(6) Үнэ цэнийн бууралт

(i) Дериватив бус санхүүгийн хөрөнгө

Компани хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын санг (i) хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө, (ii) БДОБҮЦ-ээр хэмжсэн өрийн хөрөнгө оруулалт (iii) гэрээний хөрөнгийн хувьд хүлээн зөвшөөрдөг. Компани алдагдлын санг 12 сарын хугацаанд хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын сангаар хэмжсэн дараахаас бусад хөрөнгийн хувьд уг хөрөнгийн эзэмших эрх дуусах хүртэлх хугацаанд хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын санг хэмждэг. Үүнд:

- Тайлангийн өдрөөр хүлээгдэж буй эрсдэлийг бага гэж тодорхойлсон өрийн үнэт цаас; болон
- Анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш тухайн хөрөнгийн эрсдэлд мэдэгдэхүйц өсөлт үүсээгүй бусад өрийн үнэт цаас болон банкны үлдэгдэл

Анхны хүлээн зөвшөөрөлтөөс хойш тухайн санхүүгийн хөрөнгийн эрсдэлд мэдэгдэхүйц өсөлт үүссэн эсэхийг тодорхойлж, хүлээгдэж буй эрсдэлийн алдагдлын санг тооцохын тулд компани нь холбоотой бөгөөд аливаа нэмэлт зардал эсвэл хүчин чармайлт гаргахгүйгээр олж авах боломж бүхий үндэслэлтэй бөгөөд нотлогдохүйц мэдээллүүдийг харгалзан үздэг. Үүнд компанийн түүхэн мэдээлэлд үндэслэн чанарын болон тоон үзүүлэлтэнд шинжилгээ хийх, мэдээлсэн эрсдэлийн үнэлгээ болон ирээдүйн тоон мэдээлэл багтана.

Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн алдагдлын санг тухайн хөрөнгийн нийт дансны үнээс хасна. БДОБҮЦ-ээр хэмжсэн өрийн үнэт цаасын хувьд алдагдлын санг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрч, санхүүгийн байдлын тайлан дах санхүүгийн хөрөнгийн дансны үнийг бууруулахгүй.

(ii) Санхүүгийн бус хөрөнгө

Компанийн санхүүгийн бус хөрөнгүүдийн дансны үнэд хөрөнгийн үнэ цэнэ буурч болзошгүй болохыг илтгэх шинж тэмдэг байгаа эсэхийг тайлант үе бүрийн эцэст үнэлдэг. Хэрэв ийм шинж тэмдэг илэрвэл хөрөнгийн нөхөгдөх дүнг тооцоолдог.

Компани бие даасан хөрөнгийн нөхөгдөх дүнг тооцдог ба хэрэв хөрөнгийн бие даасан нөхөгдөх дүнг тооцоолох боломжгүй бол компани хөрөнгөтэй хамааралтай мөнгөн хөрөнгө бий болгогч нэгжийн нөхөгдөх дүнг тодорхойлдог. Мөнгөн хөрөнгө бий болгогч нэгж гэдэг нь бусад хөрөнгө буюу хөрөнгийн бүлгээс орох мөнгөн орлогын урсгалаас ихээхэн хамааралтай мөнгөн орлогыг үүсгэдэг хөрөнгийн тодорхойлж болох хамгийн бага бүлэг юм.

Мөнгөн хөрөнгө бий болгогч нэгжийн хувьд нөхөгдөх дүн нь мөнгөн хөрөнгө бий болгогч нэгжийн борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэнэ болон ашиглалтын үнэ цэнийн аль их нь байдаг. Ашиглалтын үнэ цэнийг тооцохдоо хөрөнгийн хувьд онцлог эрсдэл болон мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн одоогийн зах зээлийн үнэлгээг тусгасан татварын өмнөх хувь хэмжээг ашиглан хөрөнгийг тасралтгүй ашигласнаас болон ашиглагдахаар тооцсон хугацааны эцэст данснаас хасах үед үүсэхээр хүлээгдэж буй тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнээр хэмждэг.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд, үргэлжлэл

(6) Үнэ цэнийн бууралт, үргэлжлэл

(ii) Санхүүгийн бус хөрөнгө, үргэлжлэл

Үнэ цэнийн бууралтын гарзыг хөрөнгө эсвэл мөнгөн хөрөнгө бий болгогч нэгжийн дансны үнэ нь нөхөгдөх дүнгээс хэтэрсэн үед хүлээн зөвшөөрдөг. Үнэ цэнийн бууралтын гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

Нөхөгдөх дүнг тодорхойлоход хийгдсэн тооцоололд өөрчлөлт орсон бол үнэ цэнийн бууралтын гарзыг буцаана. Үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд хөрөнгийн байх байсан дансны үнээс элэгдэл хорогдлыг хассан цэвэр дүнгээс хэтрэхгүй хэмжээгээр буцаана.

(7) Ажилчдын тэтгэвэр, тэтгэмж, урамшуулал

Тодорхой шимтгэл бүхий тэтгэвэр, тэтгэмжийн хөтөлбөр

Ажилчдын тэтгэвэр, тэтгэмж нь Монгол Улсын Нийгмийн Даатгалын Санд төвлөрүүлэх хуулиар тогтоосон нийгмийн даатгалын шимтгэлээс бүрдэнэ. Тодорхой шимтгэлийн дүн бүхий тэтгэвэр, тэтгэмжийн хөтөлбөрт төвлөрүүлэх шимтгэлийг түүнийг төлөх үүрэг хүлээсэн тайлант үеийн зардлаар бүртгэдэг.

(8) Нөөц ба болзошгүй өр төлбөр

Компани нь өнгөрсөн үйл явдлын үр дүнд өнөөгийн хуулиар хүлээсэн эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээсэн, уг үүрэг хариуцлагын төлбөрийг барагдуулахад эдийн засгийн өгөөж бүхий нөөц шаардлагатай гэдэг нь тодорхой болсон ба үүрэг хариуцлагын дүнг найдвартай тооцоолох боломжтой болсон үед санхүүгийн байдлын тайланд нөөцийг хүлээн зөвшөөрдөг. Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ нь материаллаг нөлөөтэй бол ирээдүйн мөнгөн зарлагын дүнг татварын өмнөх дискаунтын хувиар дискаунтлан нөөцийн дүнг тодорхойлдог. Дискаунтын хувь нь мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ болон тухайн өр төлбөртэй холбоотой эрсдлийн өнөөгийн зах зээлийн үнэлэмжийг тусгасан байх ёстой. Дискаунтыг буцааснаар үүсэх зардлыг санхүүгийн зардал гэж бүртгэдэг.

Эдийн засгийн өгөөжийг зарцуулах магадлал бага эсвэл зардлын дүнг найдвартай тооцоолох боломжгүй бол энэхүү үүргийг болзошгүй өр төлбөр гэж тайлагнадаг. Эдийн засгийн өгөөжийг зарцуулах магадлал маш бага бол болзошгүй өр төлбөр гэж үзэхгүй. Боломжит өр төлбөрүүд нь бодитой болох эсэх нь ирээдүйд нэг ба түүнээс дээш үйл явдлаас хамаарч байвал мөн болзошгүй өр төлбөрөөр тайлагнадаг. Эдийн засгийн өгөөжийг зарцуулах магадлал маш бага бол болзошгүй өр төлбөр гэж үзэхгүй.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд, үргэлжлэл

(9) Орлого хүлээн зөвшөөрөлт

Компани нь СТОУС 15-ыг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлж эхэлсэн (Тодруулга 2(б)-г харна уу). Компани нь харилцагчиддаа амласан бараа, ажил үйлчилгээг олгосон үед түүний үр дүнд хүлээн авахаар хүлээгдэж буй үнээр орлогоо хүлээн зөвшөөрдөг.

Компанийн орлогын үндсэн төрөл дараах байдалтай байна:

- Өмчийн үнэт цаас болон бондын арилжаалагдсан дүн дээр үндэслэсэн брокерын арилжааны төлбөр;
- Үнэт цаас нь хөрөнгийн биржид арилжаалагддаг бүртгэлтэй хувьцаат компаниудын үнэт цаас арилжаалах анхны эрхийн бүртгэлийн хураамж, дараах жилүүдийн бүртгэлийн хураамж ба нэмж үнэт цаас арилжаалах хураамж;
- Гишүүн брокер компаниудын арилжааны платформ ашиглах анхны гишүүнчлэлийн бүртгэлийн хураамж ба эрхийн жилийн хураамж.

Түүнчлэн мэдээлэл нийлүүлэх, сургалт явуулах, багцын арилжааны шимтгэл болон өргөдөл хянах зэрэг бусад үйлчилгээнээс орлого бүрддэг.

(10) Санхүүгийн орлого ба зардал

Санхүүгийн орлогод хөрөнгө оруулалтаас хүртэх хүүгийн орлого орох ба үүнийг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг. Хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн түвшин ашиглан тооцож, ашиг, алдагдлаар хуримтлуулан бүртгэдэг. Санхүүгийн зардал нь зээлийн хүүгийн зардал болон нөөцийн хөнгөлөлтөөс бүрддэг. Хөрөнгийн худалдан авалт болон түүнийг барьж байгуулахтай шууд холбогдолгүй гарсан зээлийн хүүгийн зардлыг үр ашигт хүүгийн аргаар тооцож, дэлгэрэнгүй орлогын тайланд тусгадаг.

Гадаад валютын олз, гарзыг цэвэр дүнгээр нь санхүүгийн орлого эсвэл санхүүгийн зардлын аль нэгэнд нь тайлагнадаг.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд, үргэлжлэл

(11) Орлогын татварын зардал

Орлогын албан татварын зардал нь тайлант жилийн татвар болон хойшлогдсон татвараас бүрддэг. Тайлант жилийн татвар болон хойшлогдсон татварыг эздийн өмч эсвэл бусад дэлгэрэнгүй орлогоор шүүд хүлээн зөвшөөрөхөөс бусад тохиолдолд дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрч, бүртгэдэг.

Тайлант жилийн татварын зардал нь тухайн жилийн татвар ногдох орлогод тайлант жилийн эцсээр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа эсвэл хүчин төгөлдөр болох нь тодорхой болсон татварын хувь хэмжээг ашиглан ногдуулсан татварын ер, мөн өмнөх жилүүдийн татварын ертэй холбоотой тохируулгаас бүрдэнэ.

Хойшлогдсон татварыг санхүүгийн тайлагналын болон татварын зорилгоор тайлагнасан хөрөнгө, ер төлбөрийн дансны үнийн хооронд үүссэн түр зөрүүтэй холбоотойгоор хүлээн зөвшөөрдөг.

Тайлант жилийн эцсээр хүчин төгөлдөр болсон эсвэл хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа татварын хувь хэмжээнд үндэслэн хөрөнгө нь хэрэгжих буюу ер төлбөрийг төлөх тайлант үед мөрдөгдөхөөр хүлээгдэж буй татварын хувь хэмжээгээр хойшлогдсон татварын хөрөнгө болон ер төлбөрийг хэмждэг.

Компани тайлант жилийн болон хойшлогдсон татварын дүнг тодорхойлохдоо татвартай холбоотой тодорхойгүй нөхцөл байдал, нэмэлт татвар болон хүү төлөгдөх магадлал гэх мэт хүчин зүйлсийн нөлөөг тооцож үздэг. Татварын хууль тогтоомжийн тайлбар, өмнөх жилүүдийн туршлага гэх мэт олон хүчин зүйлсийг үнэлсний үндсэн дээр компани татварын ер төлбөрөө нээлттэй татварын жилүүдэд хангалттай хэмжээнд хуримтлуулсан гэж үзэж байна. Энэхүү үнэлгээ нь компанийн ирээдүйн үйл явдлын талаарх тооцоолол, таамаглал болон олон хувилбарт үнэлэмжид үндэслэдэг. Одоогийн хуримтлуулсан татварын ер төлбөрийн хангалттай байдлын талаарх компанийн үнэлэмжид нөлөө үзүүлж болохуйц шинэ мэдээлэл, нөхцөл байдал үүсч болох юм. Энэхүү нөлөө нь тухайн ер төлбөрийг тодорхойлсон тайлант хугацааны татварын зардалд нөлөөлнө.

Компани хойшлогдсон татварын хөрөнгө, ер төлбөрийн цэвэр дүнг гаргах хууль ёсны хүчин төгөлдөр эрхтэй бөгөөд түүнд ногдуулсан татварыг компанийг хариуцсан нэг татварын байгууллагаас ногдуулсан тохиолдолд хойшлогдсон татварын хөрөнгө, ер төлбөрийг цэвэр дүнгээр тайлагнаж болно.

Ашиглагдаагүй татварын алдагдал, хөнгөлөлт болон татвар ногдох орлогоос хасагдах түр зөрүүг тэдгээрийг ашиглаж болохуйц хэмжээний ирээдүйн татвар ногдох орлого олох нь магадлалтай хэмжээгээр хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрдөг. Хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг тайлант жилийн эцэс бүрт дахин хянаж үздэг. Хойшлогдсон татварын хөрөнгийн өгөөжийг ашиглах боломжтой хангалттай хэмжээний татвар ногдох ашиг олох магадлал үгүй болох хэмжээгээр компани нь хойшлогдсон татварын хөрөнгийн дансны үнийг бууруулдаг.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

3. Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогууд, үргэлжлэл

(12) Хувьцаат капитал

Энгийн хувьцаа

Энгийн хувьцааг эздийн өмчийн хэсэгт ангилж, бүртгэдэг. Энгийн хувьцаа нэмж гаргахтай холбоотой нэмэгдэл зардлыг татварын нөлөөллийн дараах цэвэр дүнгээр нь эздийн өмчийн бууралтаар хүлээн зөвшөөрдөг.

(13) Холбоотой талууд

(i) Аливаа хувь хүн эсвэл түүний гэр бүлийн ойр дотны гишүүнийг дараах тохиолдолд компанитай холбоотой гэж үзнэ:

- Компанийг хянадаг эсвэл хамтран хянадаг;
- Компанид мэдэгдэхүйц нөлөөлөлтэй;
- Компанийн эсвэл түүний толгой компанийн тэргүүлэх удирдлагын гишүүн бол.

(ii) Дараах нөхцөлүүдийн аль нэг нь хангагдаж байвал тухайн аж ахуйн нэгж компанитай холбоотой гэж үзнэ:

- Тухайн аж ахуйн нэгж болон компани нь нэг группын бүрэлдэхүүнд багтаж байвал (өөрөөр хэлбэл, толгой компани, охин компани болон нэг толгой компанид хамаардаг охин компаниуд бүгд бусадтайгаа холбоотой);
- Нэг аж ахуйн нэгж нь нөгөө аж ахуйн нэгжийн хараат компани эсвэл хамтын хяналттай компани бол (эсвэл нөгөө аж ахуйн нэгжийг багтаасан группын нэг аж ахуйн нэгжийнх нь хараат эсвэл хамтын хяналттай компани бол);
- Хоёр аж ахуйн нэгж хоёулаа гуравдагч талын хамтын хяналттай компани бол;
- Нэг аж ахуйн нэгж нь гуравдагч талын хамтын хяналттай компани ба харин нөгөө аж ахуйн нэгж нь уг гуравдагч талын хараат компани бол;
- Тухайн аж ахуйн нэгж нь компани эсвэл түүнтэй холбоотой аж ахуйн нэгжийн аль нэгнийх нь ажилчдын тэтгэвэр тэтгэмжинд зориулсан ажил эрхлэлтийн дараах тэтгэмжийн төлөвлөгөө бол;
- (i)- тодорхойлсон хувь хүн тухайн аж ахуйн нэгжид хяналт тавьдаг эсвэл хамтран хянадаг бол;
- (i)-д тодорхойлсон хувь хүн тухайн аж ахуйн нэгжид мэдэгдэхүйц нөлөөтэй эсвэл уг аж ахуйн нэгж (эсвэл түүний толгой компанийн)-ийн тэргүүлэх удирдлагын гишүүн бол.

Хувь хүний гэр бүлийн ойр дотны гишүүд гэдэг нь компанитай ажил хэргийн харилцаанд орох явцад хувь хүнд нөлөөлөх эсвэл түүний нөлөөнд автаж болзошгүй гэр бүлийн гишүүд юм.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

4. Компанид хүчин төгөлдөр мөрдөж эхлээгүй байгаа, шинээр гарсан СТОУС-ууд

Хэд хэдэн шинэ стандартууд, стандартын өөрчлөлтүүд 2019 оны 01 дүгээр сарын 1-ний өдрөөс хойш тайлант жилүүдэд хэрэгжиж эхэлнэ. Компанид хамааралтай стандартуудыг дор тусгасан. Компани нь эдгээр стандартуудын шаардлагын дагуу 2019 оны 01 дүгээр сарын 1-ний өдрөөс хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

СТОУС 16 Түрээс

СТОУС 16 нь түрээслэгчийн хувьд түрээсийг балансад бүртгэх бүртгэлийн загварыг танилцуулсан. Түрээслэгч нь түрээсийн хөрөнгийг ашиглах эрхийг эзэмшиж байгаагийн хувьд тухайн хөрөнгийн-ашиглах-эрхийг хүлээн зөвшөөрөх ба түрээсийн төлбөр төлөх үүргийн дагуу түрээсийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Богино хугацаат болон бага дүнтэй зүйлсийн түрээсийн хувьд чөлөөлөлтийн нөхцөлүүд тусгагдсан. Түрээслүүлэгчийн бүртгэл нь одоо мөрдөгдөж байгаа стандартаас өөрчлөгдөөгүй ба түрээслүүлэгч түрээсийг шинж чанараас нь хамааруулан санхүүгийн болон үйл ажиллагааны түрээсийн аль нэгээр нь бүртгэнэ.

Уг стандарт нь НББОУС 17 “Түрээс”, НББОУСХТ 4 “Хэлцэлд түрээсийн шинж чанар агуулагдсан эсэхийг тодорхойлох”, СТХ 15 “Үйл ажиллагааны түрээс - Урамшүүлал” болон СТХ 27 “Түрээсийн хууль эрх зүйтэй холбоотой гүйлгээний агуулгыг дүгнэх” зэрэг стандартуудыг орлоно

Уг стандарт нь 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр эсвэл түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлнэ. СТОУС 16-аг мөрдөж эхлэх үед, эсвэл анх мөрдөж эхлэхээс өмнө СТОУС 15 Харилцагчтай Байгуулсан Гэрээний Орлогын стандартыг мөрдөж байгаа аж ахуйн нэгжүүдэд заасан хугацаанаас өмнө хэрэглэхийг зөвшөөрсөн. Компани нь 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар үйл ажиллагааны түрээсийн гэрээнд түрээслэгчээр ороогүй байгаа түл СТОУС 16-ын нөлөөллийн үнэлгээг хийгээгүй болно.

Бусад стандартууд

Дараахь нэмэлт өөрчлөлтүүд болон тайлбарууд нь Компанийн санхүүгийн тайланд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхгүй болно.

- *СТОУТХ 23 Татварын тооцооллын тодорхой бус байдал*
- *Сөрөг нөхөн төлбөртэй урьдчилсан төлбөрийн онцлогууд (СТОУС 9-д оруулсан нэмэлт өөрчлөлтүүд)*
- *Хараат компани ба хамтарсан үйлдвэр дэх урт хугацааны ашиг сонирхол (НББОУС 28-д оруулсан өөрчлөлтүүд)*
- *Нэмэлт өөрчлөлт, хөнгөлөлт, төлбөр тооцоо (НББОУС 19-д оруулсан өөрчлөлтүүд)*
- *СТОУС-ын стандартын жил бүрийн сайжруулалт 2015-2017 оны цикл - янз бүрийн стандартууд*
- *СТОУС 17 Даатгалын гэрээ.*

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

5. Үндсэн хөрөнгө

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн үндсэн хөрөнгийн хөдөлгөөн дараах байдалтай байна.

(Мянган төгрөгөөр)	Барилга байгууламж	Тоног төхөөрөмж	Тээврийн хэрэгсэл	Тавилга, эд хогшил	Нийт
Өртөг:					
2018 оны 01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл	2,500,587	1,039,304	135,376	307,543	3,982,810
Нэмэгдсэн	-	34,934	-	2,332	37,266
Биет бус хөрөнгөнд шилжүүлсэн	(13,361)	-	-	-	(13,361)
Данснаас хассан	-	(139,027)	-	(20,777)	(159,804)
2018 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	2,487,226	935,211	135,376	289,098	3,846,911
Хуримтлагдсан элэгдэл:					
2018 оны 01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл	415,299	921,524	135,376	246,519	1,718,718
Байгуулсан элэгдэл	42,091	55,203	-	18,701	115,995
Данснаас хассан	-	(139,027)	-	(20,777)	(159,804)
2018 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	457,390	837,700	135,376	244,443	1,674,909
Үлдэгдэл өртөг:					
2017 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	2,085,288	117,780	-	61,024	2,264,092
2018 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	2,029,836	97,511	-	44,655	2,172,002

Улаанбаатар хотын төвд байрлах компанийн оффисын барилга нь компанид холбогдох газар эзэмших эрхийн хамт 2007-2013 онд үе шаттайгаар шилжсэн. Уг шилжилт нь Засгийн Газар (Төрийн Өмчийн Хороогоор дамжуулан) болон компани хоорондын гэрээнд суурилсан ба хувьцаа эзэмшигчээс оруулсан хувь нэмэр байдлаар эздийн өмчид бүртгэсэн бөгөөд түүний дараа хувьцаат капитал руу хөрвүүлсэн. Засгийн Газар 100%-ийн төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ олгодоггүй тул компани хөрөнгийн эзэмшлийн гэрчилгээгүй байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

5. Үндсэн хөрөнгө, үргэлжлэл

2018 онд, Компани нь ТӨХК-ийн үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээг хийх тухай Монгол Улсын Засгийн Газрын шийдвэрийн дагуу Сангийн Сайдын баталсан аргачлалын хүрээнд, барилга байгууламж болон газрын дахин үнэлгээг хийсэн. Компани барилга байгууламж болон тоног төхөөрөмжийн хэмжилтэд СТОУС-ын дагуу өртгийн загварыг мөрдөж байгаа тул дахин үнэлгээний үр дүнг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөөгүй болно. Компанийн няглан бодох бүртгэлийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг Тодруулга 3 (4) -с үзнэ үү.

2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн үндсэн хөрөнгийн хөдөлгөөн дараах байдалтай байна.

<i>(Мянган төгрөгөөр)</i>	Барилга байгууламж	Тоног төхөөрөмж	Тээврийн хэрэгсэл	Тавилга эд хогшил	Нийт
Өртөг:					
2017 оны 01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл	2,500,177	1,027,624	135,376	297,744	3,960,921
Нэмэгдсэн	410	11,680	-	9,799	21,889
Хасагдсан	-	-	-	-	-
2017 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	2,500,587	1,039,304	135,376	307,543	3,982,810
Хуримтлагдсан элэгдэл:					
2017 оны 01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл	373,241	861,499	126,001	228,830	1,589,571
Байгуулсан элэгдэл	42,058	60,025	9,375	17,689	129,147
Хасагдсан	-	-	-	-	-
2017 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	415,299	921,524	135,376	246,519	1,718,718
Үлдэгдэл өртөг:					
2016 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	2,126,936	166,125	9,375	68,914	2,371,350
2017 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	2,085,288	117,780	-	61,024	2,264,092

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дүүсгавар болсон жилийн
 Санхүүгийн Тайлангийн Тодруулга

6. Биет бүс хөрөнгө

Биет бүс хөрөнгө нь программ хангамжийн лицензээс бүрдэнэ. 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх биет бүс хөрөнгө дансны үлдэгдэл дараах байдалтай байна:

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>2018</u>	<u>2017</u>
Өртөг:		
01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл	7,970,685	7,970,685
Нэмэгдсэн	422,673	-
Үндсэн хөрөнгөөс шилжүүлсэн	13,361	-
Данснаас хассан	<u>(54,367)</u>	<u>-</u>
12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	8,352,352	7,970,685
Хуримтлагдсан хорогдол:		
01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл	6,698,785	6,207,002
Байгуулсан хорогдол	515,265	491,783
Данснаас хассан	<u>(54,367)</u>	<u>-</u>
12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	<u>7,159,683</u>	<u>6,698,785</u>
12 дугаар сарын 31-ний цэвэр үлдэгдэл	<u>1,192,669</u>	<u>1,271,900</u>

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт биет бүс хөрөнгийн 778,966 мянган төгрөг нь (2017: 1,269,177 мянган төгрөг) нь Милленниум Ай Ти системтэй холбоотой байна. 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр биет бүс хөрөнгийн 399,192 мянган төгрөгийн үнэ цэнэ нь 2018 онд худалдаж авсан Oracle програм хангамжтай холбоотой.

7. Бараа материал

Бараа материал нь оффисын хангамжийн материал болон бага үнэтэй төхөөрөмж, эд зүйлсээс бүрдэнэ. 2018 болон 2017 онд бараа материалын үнэ цэнийн бууралттай холбоотойгоор зардал нэмж хүлээн зөвшөөрөөгүй.

8. Бусад хөрөнгө оруулалт

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх бусад хөрөнгө оруулалтын үлдэгдэл дараах байдалтай байна:

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>2018</u>	<u>2017</u>
Засгийн Газрын бонд – хорогдуулсан өртгөөр илэрхийлсэн	<u>1,000</u>	<u>1,000</u>
	<u>1,000</u>	<u>1,000</u>

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
 Санхүүгийн Тайлангийн Тодруулга

9. Дансны авлага

(1) 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дансны авлагын дансны үлдэгдлийг хураангуйлан харуулбал дараах байдалтай байна:

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>2018</u>	<u>2017</u>
Дансны авлага	550,614	342,759
Үнэ цэнийн бууралтын нөөц	<u>(251,153)</u>	<u>(259,907)</u>
	<u>299,461</u>	<u>82,852</u>

Авлага цуглуулах дундаж хугацаа борлуулалтын нэхэмжлэл гаргасан өдрөөс хойш 90 хүртэл хоног байдаг. Дансны авлагад хүү тооцдоггүй.

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар дансны авлагын 228,995 мянган төгрөг Арилжааны Төлбөр Тооцоо ХХК-с авах авлага байна (2017 онд: 171,500 мянган төгрөг нэг харилцагчаас авах авлагын дүн байсан). 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Арилжааны Төлбөр Тооцоо ХХК-с авах авлага хугацаа хэтрээгүй байна.

Үлдсэн дансны авлагын дүн нь голдуу хөрөнгийн биржид бүртгэлтэй гишүүн брокер болон хувьцаат компаниудаас авах авлагаас бүрдэж байна.

(2) Хугацаа хэтэрсэн боловч үнэ цэнийн бууралтгүй дансны авлагын насжилт:

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>2018</u>		<u>2017</u>	
	Дансны авлага	Үнэ цэнийн бууралтын нөөц	Дансны авлага	Үнэ цэнийн бууралтын нөөц
Хугацаа хэтрээгүй ба үнэ цэнийн бууралтгүй	236,194	-	-	-
Хугацаа хэтэрсэн (0 - 30 өдөр)	-	-	-	-
Хугацаа хэтэрсэн (30 - 90 өдөр)	-	-	-	-
Хугацаа хэтэрсэн (91 - 150 өдөр)	-	-	-	-
Хугацаа хэтэрсэн (151 - 365 өдөр)	21,307	(4,675)	31,305	-
Хугацаа хэтэрсэн (365-аас дээш өдөр)	<u>293,113</u>	<u>(246,478)</u>	<u>311,454</u>	<u>(259,907)</u>
	<u>550,614</u>	<u>(251,153)</u>	<u>342,759</u>	<u>(259,907)</u>

Харилцагчийн талаарх үнэлгээнд үндэслэн 30 хоногоос дээш хугацаа хэтрэлттэй авлагууд нь цуглуулагдах боломжтой гэж компани үзэж байна.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
 Санхүүгийн Тайлангийн Тодруулга

9. Дансны авлага, үргэлжлэл

(3) Дансны авлагын үнэ цэнийн бууралтын нөөцийн өөрчлөлтийг хураангуйлан харуулбал дараах байдалтай байна:

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>2018</u>	<u>2017</u>
01 дүгээр сарын 01-ний үлдэгдэл	259,907	366,227
Нэмэгдсэн	18,171	27,375
Ашиглагдсан	(26,925)	(121,433)
Буцаасан	-	(12,262)
12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	<u>251,153</u>	<u>259,907</u>

2018 онд 18,171 мянган төгрөг (2017: 27,375 мянган төгрөг)-ийн авлагын үнэ цэнийн бууралтын нөөцийг нэмж хүлээн зөвшөөрсөн ба 26,925 мянган төгрөгийн (2017: 121,433 мянган төгрөг) нөөцийг данснаас хассан байна.

Компанийн зээлийн эрсдэл болон валютын эрсдэлийг Тодруулга 20-с үзнэ үү.

10. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн үлдэгдэл дараах байдалтай байна:

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>2018</u>	<u>2017</u>
Касс дахь бэлэн мөнгө	2,347	1,125
Харилцах дахь мөнгө	<u>828,039</u>	<u>1,305,759</u>
	<u>830,386</u>	<u>1,306,884</u>

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
 Санхүүгийн Тайлангийн Тодруулга

11. Хувьцаат капитал

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>Тоо ширхэг (мянгачилсан)</u>	<u>Мянган төгрөгөөр</u>
2017 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	218,840	21,884,000
Хувьцаа гаргалт	12,466	1,246,594
2018 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл	<u>231,306</u>	<u>23,130,594</u>

2018 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн Сангийн Яамны 68 дугаар тогтоолын дагуу хувьцаат капиталыг нэг бүрийн нэрлэсэн нь 100 төгрөгөөр үнэлэгдсэн 12,465,936 ширхэг хувьцаагаар бусад нөөцөөс хувьцаат капиталруу адил дүнгээр хөрвүүлэн нэмэгдүүлсэн.

Бусад нөөц нь Милленниум Ай Ти системийн худалдан авалт болон үйл ажиллагааг нь хангахтай холбоотой хувьцаа эзэмшигчээс 2011 оноос 2017 оны хооронд оруулсан санхүүжилт юм. 2018 онд компани нь хувьцаа эзэмшигчээс санхүүжилт хүлээн аваагүй (2017: 1,246,594 мянган төгрөг) болно.

12. Дансны болон бусад өглөг

1) 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дансны өглөг дансны үлдэгдэл дараах байдалтай байна:

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>2018</u>	<u>2017</u>
Дансны өглөг – гадаад	1,038,668	310,423
Дансны өглөг – дотоод	13,337	14,577
	<u>1,052,005</u>	<u>325,000</u>

2) 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх бусад өглөг дансны үлдэгдэл дараах байдалтай байна:

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>2018</u>	<u>2017</u>
Цалингийн өглөг	35,975	788
Суутган татварын өглөг	102,107	31,042
Бусад татварын өглөг	17,950	9,494
	<u>156,032</u>	<u>41,324</u>

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
 Санхүүгийн Тайлангийн Тодруулга

13. Орлого

Орлого дансны дэлгэрэнгүй дараах байдалтай байна:

<i>(Мянган төгрөгөөр)</i>	2018	2017
Орлого		
Арилжааны шимтгэл	1,031,556	1,209,763
Бүртгэл болон үйлчилгээний хураамж	228,415	262,727
Бүртгэлтэй компанийн жилийн хураамж	180,545	155,952
Брокер компанийн гишүүнчлэлийн хураамж	79,779	77,392
Мэдээлэл нийлүүлсний хураамж	47,749	41,887
Терминал ашигласны хураамж	44,141	32,795
Бусад орлого	44,775	50,037
	<u>1,656,960</u>	<u>1,830,553</u>

Компани нь анх 2018 оны 01 дүгээр сарын 01-ээс эхлэн СТОУС 15-ыг мөрдөж эхэлсэн. СТОУС 15 нь компанийн орлогын урсгал болон түүний гүйцэтгэлийн үүргийн нягтлан бодох бүртгэлийн бодлогод мэдэгдэхүйц нөлөө үзүүлээгүй болно.

Орлогын урсгал

Компанийн орлого нь голчлон хөрөнгө оруулалтын арилжаа болон хөрөнгийн биржид бүртгэхтэй холбоотой үйлчилгээний орлогоос бүрдэнэ.

Гүйцэтгэлийн үүрэг ба орлого хүлээн зөвшөөрөх бодлого

Орлого нь харилцагчтай байгуулсан гэрээнд тусгасан төлбөрийн дүн дээр үндэслэн хэмжигдэнэ. Компани нь үйлчлүүлэгчдээ бүтээгдэхүүн эсвэл үзүүлж буй үйлчилгээний хяналтыг шилжүүлснээр, эсвэл тодорхой хугацааны туршид үйлчилгээ үзүүлэх явцад орлого хүлээн зөвшөөрдөг.

Дараах хүснэгтэд үйлчлүүлэгчтэй байгуулсан гэрээний гүйцэтгэлийн үүргийн хангалтын шинж чанар, цаг хугацааны талаархи мэдээлэл ба холбогдох орлого хүлээн зөвшөөрөх бодлогын тусгасан.

Бүтээгдэхүүн/ үйлчилгээний төрөл	Нөлөө бүхий төлбөрийн нөхцөлийг оруулсан үүргийн шинж чанар ба цаг хугацааны гүйцэтгэл	СТОУС 15-ын дагуу орлогын хүлээн зөвшөөрөлт (2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжих)	НББОУС 18-ын дагуу орлогын хүлээн зөвшөөрөлт (2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн өмнө хэрэгжих)
Арилжаа	Энэ нь хөрөнгийн бирж дэх хувьцаа, үнэт цаасны арилжааны шимтгэл. Арилжаа явагдаж дуусахад гүйцэтгэлийн үүрэг хангагдана. Арилжааны нэхэмжлэхийг дараагийн өдөр Арилжаа Төлбөр Тооцоо ХХК-д гаргана.	Арилжаа хийгдэх өдөр буюу үйлчилгээ үзүүлж дуусах үед орлогыг хүлээн зөвшөөрдөг.	Арилжаа хийгдэх өдөр буюу үйлчилгээ үзүүлж дуусах үед орлогыг хүлээн зөвшөөрдөг.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
 Санхүүгийн Тайлангийн Тодруулга

13. Орлого, үргэлжлэл

Гүйцэтгэлийн үүрэг ба орлого хүлээн зөвшөөрөх бодлого, үлгэлжлэл

Бүтээгдэхүүн/ үйлчилгээний төрөл	Нөлөө бүхий төлбөрийн нөхцөлийг оруулсан үүргийн шинж чанар ба цаг хугацааны гүйцэтгэл	СТОУС 15-ын дагуу орлогын хүлээн зөвшөөрөлт (2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжих)	НББОУС 18-ын дагуу орлогын хүлээн зөвшөөрөлт (2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн өмнө хэрэгжих)
Бүртгэлийн үйлчилгээ	Үүнд хөрөнгийн биржид бүртгүүлэхтэй холбоотой үйлчилгээ, бүртгэлийг шинэчлэх, хөрөнгийн биржид шинэчилсэн мэдээллийг бүртгэх, IPO болон үүнтэй ижил төстэй үйлчилгээ орно. Гүйцэтгэлийн үүргийг бүртгэх ба холбогдох үйлчилгээг дуусахад хангасан гэж үзнэ.	Бүртгэл ба холбогдох үйлчилгээг хөрөнгийн биржид гүйцэтгэж үйлчлүүлэгчээр баталгаажуулсан өдөр буюу үйлчилгээ үзүүлж дууссан үед орлогыг хүлээн зөвшөөрдөг.	Бүртгэл ба холбогдох үйлчилгээг хөрөнгийн биржид гүйцэтгэж үйлчлүүлэгчээр баталгаажуулсан өдөр буюу үйлчилгээ үзүүлж дууссан үед орлогыг хүлээн зөвшөөрдөг.
Жилийн болон гишүүнчлэлийн хураамж	Брокеруудад гишүүнчлэлийн төлбөрийн нэхэмжлэхийг улирлаар явуулдаг. Бүртгэлтэй аж ахуйн нэгжийн жилийн хураамжийн нэхэмжлэхийг хагас жилээр явуулдаг.	Тодорхой хугацааны туршид үйлчилгээ үзүүлэх явцад орлого хүлээн зөвшөөрдөг.	Тодорхой хугацааны туршид үйлчилгээ үзүүлэх явцад орлого хүлээн зөвшөөрдөг.
Мэдээлэл хангамж ба терминал ашиглалтын эрх	Үүнд: - Үнийн, арилжааны, болон бусад мэдээллийн хангамж - Худалдааны болон клирингийн системээс бий болсон зах зээлийн мэдээллийн хангамж - Бирж, тооцооны болон мэдээллийн төвийн холболтын эрх олголт. Дээрх үйлчилгээний гэрээний хугацаа, шинж чанарын хувьд ижил төстэй. Мэдээллийн үйлчилгээний орлого нь ихэвчлэн захиалгын дагуу сар, улирал, жилээр урьдчилан тооцоологддог бөгөөд мэдээллийн нийлүүлэлтийн гүйцэтгэлийн үүргийг гэрээт хугацааны туршид тогтмол хангаж байна.	Тодорхой хугацааны туршид үйлчилгээ үзүүлэх явцад орлого хүлээн зөвшөөрдөг.	Тодорхой хугацааны туршид үйлчилгээ үзүүлэх явцад орлого хүлээн зөвшөөрдөг.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
 Санхүүгийн Тайлангийн Тодруулга

14. Ерөнхий ба удирдлагын зардал

Компанийн ерөнхий ба удирдлагын зардлыг хураангуйлан харуулбал дараах байдалтай байна:

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>2018</u>	<u>2017</u>
Цалингийн зардал	853,483	803,626
Элэгдэл, хорогдлын зардал	141,049	130,719
Терминалын хураамж	67,190	59,061
Ашиглалт, харилцаа холбооны зардал	56,958	58,668
Томилолтын зардал	36,937	24,569
Арга хэмжээ, сургалт ба хандив	27,275	25,080
Мэргэжлийн үйлчилгээний зардал	20,833	21,709
Засвар, үйлчилгээний зардал	17,583	28,782
Бусад зардал	69,126	58,237
	<u>1,290,434</u>	<u>1,210,451</u>

15. Милленниум Ай Ти системтэй холбоотой зардал

Компани 2012 онд Лондонгийн Хөрөнгийн Бирж Группын бүтээгдэхүүн болох Милленниум Ай Ти арилжааны системийг авч суурилуулан нэвтрүүлсэн. Уг системийн тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой зардлыг тусад нь тодруулсан. Милленниум Ай Ти системтэй шүүд холбоотой компанийн үйл ажиллагааны зардлыг харуулбал дараах байдалтай байна:

Тайлант жилийн Милленниум Ай Ти системтэй холбоотой зардал:

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>2018</u>	<u>2017</u>
Засварын зардал	687,213	311,689
Хорогдлын зардал	490,211	490,211
Суутгасан нэмэгдсэн өртгийн албан татвар	68,721	79,225
Сервер үйлчилгээний зардал	27,624	27,624
	<u>1,273,769</u>	<u>908,749</u>

2016 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн Лондонгийн Хөрөнгийн Бирж Лимитэд (ЛХБ) болон Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК (МХБ) хооронд байгуулсан ЛХБ-ийн дэмжлэг үзүүлдэг Эм Ай Ти системийн OPS Өргөтгөл Үйлчилгээний гэрээний хугацаа 2017 оны 3 дугаар сарын 01-нд дууссан. Энэхүү гэрээний дагуу компани нь Милленниум Ай Ти системийн дэмжлэгийн хураамж болгон ЛХБ-д сар бүр 16,000 ам.доллар төлөх шаардлагатай байсан.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
 Санхүүгийн Тайлангийн Тодруулга

15. Миллениум Ай Ти системтэй холбоотой зардал, үргэлжлэл

2018 оны 10 дугаар сарын 18-ны өдөр OPS Өргөтгөл Үйлчилгээний гэрээний хугацааг дахин хоёр жилийн хугацаагаар сунгасан. Гэрээний шинэ нөхцлийн дагуу компани нь 2017 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үйлчилгээний төлбөр болох 160,000 ам.доллараар төлөх шаардлагатай болсон. 2018 оны 10 дугаар сард гэрээт үүрэг үүссэний улмаас 2017 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хоорондох үйлчилгээний төлбөр 2018 онд бүртгэсэн байна.

Өмнөх жилийн Миллениум Ай Ти системтэй холбоотой зардал:

(Мянган төгрөгөөр)

Засварын зардал	388,341
Суутгасан нэмэгдсэн өртгийн албан татвар	38,834
	<u>427,175</u>

16. Санхүүгийн орлого

Санхүүгийн орлого нь харилцах дахь мөнгөний хүүгийн болон бондын хүүгийн орлогоос бүрдэнэ. 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 94,606 мянган төгрөг (2017: 49,199 мянган төгрөг)-ийн санхүүгийн орлогыг хүлээн зөвшөөрсөн.

17. Гадаад валютын цэвэр олз (гарз)

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх гадаад валютын цэвэр олз/(гарз) дансны мэдээллийг хураангуйлан харуулбал дараах байдалтай байна:

(Мянган төгрөгөөр)

	<u>2018</u>	<u>2017</u>
Миллениум Ай Ти системийн өглөгтэй холбоотой үүссэн гадаад валютын цэвэр олз (гарз)	(30,665)	28,229
Бусад гадаад валютын цэвэр олз (гарз)	359	(12,458)
	<u>(30,306)</u>	<u>15,771</u>

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
 Санхүүгийн Тайлангийн Тодруулга

18. Орлогын татварын зардал

- (1) Орлогын албан татварын зардал 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилд дараах байдалтай байна.

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>2018</u>	<u>2017</u>
Тайлант жилийн татварын зардал	9,444	4,920
Орлогын албан татварын зардал	<u>9,444</u>	<u>4,920</u>

- (2) 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн татварын үр ашигт хувийн тохируулга:

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>2018</u>	<u>2017</u>
Татварын өмнөх алдагдал	(1,250,401)	(228,241)
- Нийтлэг хувь хэмжээгээр тооцсон орлогын албан татвар (*)	(125,040)	(22,824)
- Тусгай хувь хэмжээгээр тооцсон орлогын татвар (10%)	9,444	4,920
-Татвар ногдох орлогоос хасагдахгүй зардал	5,588	2,895
-Татвар ногдохгүй орлогын татварын нөлөөлөл	(386)	(586)
- Хойшлогдсон татвар хүлээн зөвшөөрөгдөөгүй тайлант жилийн алдагдал	116,423	18,882
-Хүлээн зөвшөөрөгдөөгүй түр зөрүүний өөрчлөлт	<u>3,415</u>	<u>1,633</u>
Тайлант жилийн орлогын албан татвар	<u>9,444</u>	<u>4,920</u>

(*) Монгол Улсын Аж Ахуйн Нэгжийн Орлогын Албан Татварын тухай хуулийн дагуу компани нь үйл ажиллагаанаасаа орлого олж эхэлсэн бол 3 тэрбум төгрөг хүртэлх албан татвар ногдуулах жилийн орлогод 10%, 3 тэрбум төгрөгөөс давсан орлогын дүнд 25%-аар албан татвар төлөх үүрэгтэй.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
 Санхүүгийн Тайлангийн Тодруулга

18. Орлогын татварын зардал, үргэлжлэл

- (3) 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн хүлээн зөвшөөрөөгүй хойшлогдсон татварын хөрөнгийн өөрчлөлт дараах байдалтай байна.

<i>(Мянган төгрөгөөр)</i>	Эхний Үлдэгдэл	Нэмэгдсэн	Буцаасан	Эцсийн үлдэгдэл
Гадаад валютын ханшийн зөрүү	22,779	5,588	22,779	5,588
Татварын алдагдал	165,189	116,423	146,307	135,305

- (4) 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн хүлээн зөвшөөрөөгүй хойшлогдсон татварын хөрөнгийн өөрчлөлт дараах байдалтай байна.

<i>(Мянган төгрөгөөр)</i>	Эхний Үлдэгдэл	Нэмэгдсэн	Буцаасан	Эцсийн үлдэгдэл
Гадаад валютын ханшийн зөрүү	21,146	1,633	-	22,779
Татварын алдагдал	247,623	18,882	101,316	165,189

- (5) Монгол Улсын Засгийн Газар зах зээлийн эдийн засагт шилжсэнээс хойш бизнес болон арилжааны дэд бүтцийг шинэчилсээр байгаа. Үүнтэй холбоотойгоор бизнесийн үйл ажиллагаанд нөлөө үзүүлэхүйц хууль тогтоомж, дүрэм журмууд хурдацтай өөрчлөгдөн шинэчлэгдэж байна.

Эдгээр өөрчлөлтүүд нь зарим тохиолдолд хуулийн хангалтгүй боловсруулалт, маргаантай тайлбар, болон татварын албадын ялгаатай хэрэглээ зэрэг нөхцөл байдлыг үүсгэдэг. Ялангуяа, татварыг хуулийн дагуу торгууль, алданги ногдуулах эрх бүхий олон тооны байгууллагууд хянаж шалгадаг юм. Компани нь татварын хууль тогтоомжийн талаарх өөрсдийн ойлголт болон тайлант жилийн эцэс дэх санхүүгийн үр дүнд үндэслэн татварын өр төлбөрийг зохистойгоор тооцоолж илэрхийлсэн гэж үзэж байгаа боловч дээрх нөхцөл нь компанид татварын эрсдлийг үүсгэж болзошгүй ба энэхүү эрсдлийг тоон хэмжээгээр илэрхийлэх боломжгүй юм.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
 Санхүүгийн Тайлангийн Тодруулга

19. Холбоотой талууд

- (I) 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар компанийн холбоотой талууд дараах байдалтай байсан.

Холбоотой талуудын нэрс	Холбоо хамаарал
Монгол Улсын Засгийн Газар	Хувьцаа эзэмшигч
Төрийн яамдууд, тамгын газрууд, агентлагууд болон Монгол Улсын Засгийн Газрын бусад салбар нэгжүүд; бусад төрийн өмчит аж ахуйн нэгжүүд	Хувьцаа эзэмшигчийн хяналттай
ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх удирдлага	Гол удирдах ажилтан

- (II) Холбоотой талуудын ажил гүйлгээ

(Мянган төгрөгөөр)

	Ажил гүйлгээний дүн	
	2018	2017
Холбоотой компаниудаас олсон орлого		
Бүртгэлийн хураамж	9,091	171,819
Жилийн гишүүнчлэлийн хураамж	12,120	9,995
Засгийн Газрын бондын арилжааны шимтгэл	110	734,736
Засгийн Газрын богино хугацаат үнэт цаас		
Засгийн Газрын үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалт	-	194,396
Засгийн Газрын үнэт цаасны буцаан төлөлт	-	194,396
Хувьцаа эзэмшигчээс оруулсан хувь нэмэр		
Хувьцаа эзэмшигчээс оруулсан санхүүжилт	-	1,246,594
Гол удирдах ажилтнуудын цалин, урамшуулал		
Гол удирдах ажилтан	73,182	70,189
Татвар болон нийгмийн даатгал		
Суутгасан нэмэгдсэн өртгийн албан татвар	113,866	144,852
Суутгасан орлогын албан татвар	12,622	25,419
Орлогын албан татвар	9,444	4,920
Нийгмийн даатгал	93,039	81,527

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дүүсгавар болсон жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

19. Холбоотой талууд, үргэлжлэл

(III) Холбоотой талуудын дансны үлдэгдэл

(Мянган төгрөгөөр)

	Үлдэгдэл	
	2018	2017
Засгийн Газрын богино хугацаат хөрөнгө оруулалт		
Засгийн Газрын үнэт цаас	1,000	1,000
Татвар		
Орлогын албан татварын өглөг	5,451	5,136
Нэмэгдсэн өртгийн албан татварын өглөг	4,301	9,491
Суутган татварын өглөг	100,414	31,042

20. Санхүүгийн эрсдлийн удирдлага

Тойм

Компани санхүүгийн хэрэглүүрээс үүсэх дараах төрлийн эрсдлүүдийг хүлээж байдаг:

- Зээлийн эрсдэл
- Хөрвөх чадварын эрсдэл
- Зах зээлийн эрсдэл

Энэхүү тодруулга нь дээрх эрсдэл тус бүрийн компанид нөлөөлөх нөлөөлөл, уг эрсдлийг тооцоолох, удирдах компанийн зорилго, бодлого, авах арга хэмжээ, мөн компанийн капиталын удирдлагын талаарх мэдээллийг агуулсан.

(1) Зээлийн эрсдэл

Зээлийн эрсдэл гэдэг нь гэрээ байгуулагч тал гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс компанид санхүүгийн алдагдал үүсэх эрсдэл юм.

Санхүүгийн хөрөнгийн дансны үнэ нь зээлийн хамгийн их эрсдлийг илэрхийлж байдаг. Компанийн хамгийн их хүлээх зээлийн эрсдлийг санхүүгийн хөрөнгө тус бүрийн дансны үнээр илэрхийлэв:

(Мянган төгрөгөөр)	2018	2017
Бусад хөрөнгө оруулалт	1,000	1,000
Дансны авлага	299,461	82,852
Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлс	828,039	1,305,759
	<u>1,128,500</u>	<u>1,389,611</u>

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

20. Санхүүгийн эрсдлийн удирдлага, үргэлжлэл

(1) Зээлийн эрсдэл, үргэлжлэл

Тайлант өдрийн байдлаар компанийн зээлийн хамгийн өндөр эрсдэл Монголд төвлөрсөн байна.

Ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз дараах байдалтай байна:

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>2018</u>	<u>2017</u>
Дансны авлагын үнэ цэнийн бууралтын алдагдал	18,171	27,375
Дансны авлагын үнэ цэнийн бууралтын алдагдлын буцаалт	-	(12,262)
	<u>18,171</u>	<u>15,113</u>

Дансны авлага

Компанийн зээлийн эрсдэл нь харилцагч бүрийн онцлог шинж чанараас хамаардаг. Үүнээс гадна удирдлага нь харилцагчийн багцын зээлийн эрсдэлд нөлөөлж болохуйц хүчин зүйлсийг авч үзсэн.

Компани нь харилцагч бүрт 3 сарын төлбөрийн дээд хугацаа тогтоон дансны авлагаас үүсэх зээлийн эрсдлээ хязгаарладаг.

Компани нь дансны болон бусад авлагад барьцаа шаарддаггүй. Компанид барьцаа хөрөнгийн улмаас алдагдлын нөөц хүлээн зөвшөөрсөн дансны авлага байхгүй.

2018 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар харилцагчаар ангилсан дансны авлагын зээлийн эрсдэлийн түвшин дараах байдалтай байна:

<i>(Мянган төгрөгөөр)</i>	<u>2018</u>	<u>2017</u>
Арилжааны Төлбөр Тооцоо ХХК	228,995	-
Бүртгэлтэй хувьцаат компаниуд	117,059	114,551
Үнэт цаасны компаниуд	22,059	45,050
Бусад	<u>182,501</u>	<u>183,158</u>
	<u>550,614</u>	<u>342,759</u>

Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлс

Компани 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 828,039 мянган төгрөгийн банкин дах мөнгөн хөрөнгөтэй (2017 онд 1,305,759 мянган төгрөг). Компани олонд танигдсан санхүүгийн байгууллагад мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг байршуулах замаар зээлийн эрсдэлд өртөхийг хязгаарладаг.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
 Санхүүгийн Тайлангийн Тодруулга

20. Санхүүгийн эрсдлийн удирдлага, үргэлжлэл

(1) Зээлийн эрсдэл, үргэлжлэл

Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлс, үлгэлжлэл

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг 12 сарын хүлээгдэж буй алдагдлын аргаар хэмжих ба богино хугацаат зээлийн эрсдлийг харуулсан. Компани нь мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн зээлийн эрсдлийг оролцогч талуудын гадаад зээлийн үнэлгээнээс хамааруулан бага гэж үздэг.

(2) Хөрвөх чадварын эрсдэл

Мөнгөн үрсгалын хэлбэлзлийг бууруулах, үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх зорилгоор мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө болон санхүүгийн хэрэгслийн тоо хэмжээг тодорхойлох замаар компани хөрвөх чадварын эрсдлээ хянаж, удирддаг.

Санхүүгийн өр төлбөрүүдийн гэрээгээрх дуусах хугацааг доорх байдлаар илэрхийлэв:

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар

<i>(Мянган төгрөгөөр)</i>	Дансны үнэ	6 сараас доошхи	6 сараас 1 жил	1 жилээс дээшхи
Дансны өглөг	1,052,005	1,052,005	-	-
Бусад өглөг	156,032	156,032	-	-
	1,208,037	1,208,037	-	-

2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар

<i>(Мянган төгрөгөөр)</i>	Дансны үнэ	6 сараас доошхи	6 сараас 1 жил	1 жилээс дээшхи
Дансны өглөг	325,000	325,000	-	-
Бусад өглөг	41,324	41,324	-	-
	366,324	366,324	-	-

(3) Зах зээлийн эрсдэл

Зах зээлийн эрсдэл нь гадаад валютын ханш, хүүгийн түвшин зэрэг зах зээлийн үнийн өөрчлөлт компанийн орлого, санхүүгийн хэрэглүүрийн үнэ цэнэд нөлөөлөх эрсдэл юм. Зах зээлийн эрсдлийн удирдлагын зорилго нь өгөөжийг оновчтой байлгах зуур зах зээлийн эрсдлийг хүлээн зөвшөөрөгдөхүйц хэмжээнд удирдаж, хянах явдал юм.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
 Санхүүгийн Тайлангийн Тодруулга

20. Санхүүгийн эрсдлийн удирдлага, үргэлжлэл

(3) Зах зээлийн эрсдэл, үргэлжлэл

Валютын ханшийн эрсдэл

Компанийн бүртгэлийн валют болох төгрөгөөс бусад валютаар илэрхийлэгдсэн борлуулалт, худалдан авалт болон зээл нь гадаад валютын ханшийн эрсдлийг хүлээж байдаг. Эрсдлийг бий болгож буй гадаад валют нь ам. доллар юм.

Компанийн гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйлсээрх хөрөнгө болон өр төлбөрийн дансны үнэ дараах байдалтай байна:

<i>(Мянган төгрөгөөр)</i>	Ам.доллараар илэрхийлэгдсэн	
	2018	2017
Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлс	257	2,602
Дансны өглөг	(1,038,668)	(341,465)
Цэвэр дүн	(1,038,411)	(338,863)

Жилийн туршид ашигласан гадаад валютын ханш дараах байдалтай байна:

<i>(Төгрөгөөр)</i>	Тайлангийн өдрийн хаалтын ханш	
	2018	2017
Ам.доллар 1	2,642.92	2,427.13

Мэдрэмжийн шинжилгээ

Төгрөгийн ханш компанийн тайлант үеийн эцэст эзэмшиж буй бусад валютын ханшийн эсрэг 10 хувиар чангарахад татварын дараах ашигт дараах байдлаар нөлөөлнө. Энэ шинжилгээ нь бусад бүх эрсдлийн хүчин зүйлсийг тогтмол гэж авч үзсэн болно.

<i>(Мянган төгрөгөөр)</i>	2018	2017
Татварын дараах ашиг дахь нөлөөлөл	103,841	33,886

Бусад бүх хүчин зүйлсийг тогтмол гэж үзвэл төгрөгийн ханш компанийн тайлант үеийн эцэст эзэмшиж буй бусад валютын ханшийн эсрэг 10 хувиар сулрахад татварын дараах ашигт дээрхитэй ижил дүнгээр гэхдээ эсрэг байдлаар нөлөөлнө. Энэ шинжилгээ нь бусад бүх эрсдлийн хүчин зүйлсийг тогтмол гэж авч үзсэн болно.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

20. Санхүүгийн эрсдлийн удирдлага, үргэлжлэл

(3) Зах зээлийн эрсдэл, үргэлжлэл

Бодит үнэ цэнэ

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр бүх санхүүгийн хэрэглүүрүүд дансны үнээрээ бүртгэгдсэн ба дансны үнэ нь бодит үнэ цэнээсээ материаллаг зөрүүгүй байна.

Бодит үнэ цэнэ ба дансны үнэ

Санхүүгийн байдлын тайланд тусгагдсан санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ болон бодит үнэ цэнэ дараах байдалтай байна:

(Мянган төгрөгөөр)

	2018		2017	
	Дансны үнэ	Бодит үнэ цэнэ	Дансны үнэ	Бодит үнэ цэнэ
Санхүүгийн хөрөнгө				
Бусад хөрөнгө оруулалт	1,000	1,000	1,000	1,000
Дансны авлага	299,461	299,461	82,852	82,852
Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлс	828,039	828,039	1,305,759	1,305,759
	1,128,500	1,128,500	1,389,611	1,389,611
Санхүүгийн өр төлбөрүүд				
Дансны өглөг	1,052,005	1,052,005	325,000	325,000
Бусад өглөг	156,032	156,032	41,324	41,324
	1,208,037	1,208,037	366,324	366,324

Хүүгийн түвшний эрсдэл

Компанийн хүү тооцогдох санхүүгийн хөрөнгүүд нь ихэнхдээ тогтмол хүүтэй санхүүгийн хөрөнгүүд байгаа тул орлого болон үйл ажиллагааны мөнгөн урсгал нь зах зээлийн хүүгийн түвшний өөрчлөлтөд өртөх нь бага.

21. Тайлагналын дараах үйл явдал

Тайлангийн өдрийн дараа материаллаг, тайланд нөлөөлөхүйц үйл явдал гараагүй болно.

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ТӨХК
2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн
Санхүүгийн Тайлангийн Тодруулга

22. Санхүүгийн үүрэг хариуцлага ба болзошгүй зүйлс

(1) Хууль, эрх зүй

Бизнесийн хэвийн үйл ажиллагааны явцад компанид хуулийн арга хэмжээ авах болон гомдол хүлээн авах зэрэг асуудлууд тулгардаг. Ийм асуудлаас үүдэж болох компанийн хариуцлага нь компанийн санхүүгийн байдал болон ирээдүйн үйл ажиллагаанд материаллаг түвшинд сөргөөр нөлөөлөхгүй гэдэгт компанийн удирдлага итгэлтэй байна.

(2) Үүрэг хариуцлага

Компанид санхүүгийн тайлангийн өдрөөр санхүүгийн тайланд тодруулагдах буюу залруулагдах шаардлагатай болзошгүй өр төлбөр болон үүрэг хариуцлага байхгүй.

(3) Болзошгүй өр төлбөр

Тайлангийн өдрийн байдлаар компанийн тайлагнасан санхүүгийн тайланд залруулах болон тодруулах шаардлагатай ямар нэгэн болзошгүй өр төлбөр болон төлбөрийн хариуцлага байхгүй байна.

23. Монгол хэл дээрх орчуулга

Энэхүү санхүүгийн тайлан нь Англи болон Монгол хэл дээр бэлтгэгдсэн бөгөөд Англи болон Монгол орчуулгын хооронд утга агуулгын зөрүү үүссэн тохиолдолд Англи орчуулга хүчин төгөлдөр байна.